



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№125 /339/

2022.07.19

Цаг үе, үйл явдал

АРМИЙН ДЭЛХИЙН АВАРГЫН ХҮРЭЛ МЕДАЛЫТ ТАМИРЧИД ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ

CISM буюу Армийн Дэлхийн аварга шалгаруулах 3x3 сагсан бөмбөгийн тэмцээн энэ сарын 3-9-ний өдрүүдэд ХБНГУ-ын Варендорф хотноо зохион байгуулагдсан билээ. Анх удаа болж буйгаараа онцлог тус тэмцээнд 26 орны 30 гаруй баг тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн бөгөөд манай улсаас БХЯ-ны харьяа “Алдар” спорт хорооны “Алдар-Танан гарьд” багийн тамирчид эх орноо төлөөлөн амжилттай оролцоод өнгөрсөн бямба гарагт (2022.07.16) эх орондоо ирлээ.

Тэмцээний эрэгтэй төрөлд БНЛУ (Литва), АНУ, БНФУ-ын баг тамирчид эхний гурван байрыг эзэлсэн бол манай улсын баг тамирчид 9 дүгээрт байрт шалгарчээ. Тэгвэл эмэгтэй төрөлд I байрт ХБНГУ, II байрт БНФУ-ын баг тамирчид шалгарсан бол манай улсын баг тамирчид АНУ-ын багтай III байрын төлөөх тоглолтыг хийж 15:13-ын харьцаагаар ялалт байгуулан хүрэл медалийн эзэд болж чаджээ. Түүнчлэн гурван онооны шидэлтийн эмэгтэй



төрөлд “Алдар-Танан гарьд” багийн тамирчин, спортын мастер Ө.Индра тэргүүлж, алтан медаль хүртсэн аж.

Тэмцээний талаар “Алдар-Танан гарьд” багийн дасгалжуулагч, МУГД О.Баярцогт “Нэлээд өргөн хүрээг хамарсан, ширүүн өрсөлдөөнтэй тэмцээн болж өндөрлөлөө. Тэр тусмаа манай эрэгтэй багийн хувьд Литва, Солонгос, Америк, Францын баг тамирчид хамгийн ширүүн өрсөлдөгчид байлаа. Мөн эмэгтэй багийн хувьд Герман, Франц, АНУ-ын багууд хүчтэй өрсөлдөгчид байж, нэлээд хүнд тоглолтуудыг хийсэн. Манай охид хэдийгээр зоондоо АНУ-ын багт хожигдсон ч хүрэл медалийн төлөөх тоглолтыг маш амжилттай эргүүлж, ялсан. Мэдээж АНУ-ын шигшээ багийг хожно гэдэг амаргүй даваа байлаа. Тэр ч утгаараа тэмцээний зохион байгуулагчид болон оролцогч орнуудын баг тамирчид, багш дасгалжуулагч нар биднийг маш өндөр үнэлсэн. Тодруулбал, тамирчдын ур чадвар, авхаалж самбаа, хурд хүч, тамирчны ёс зүй өндөр түвшинд байгааг, медальт байр эзлэх тааврыг эвдсэнийг онцлон дурдсан нь манай тамирчдад их урам зориг, итгэл үнэмшлийг өгсөн”



хэмээлээ.

Мөн тамирчин Б.Цацрал “Тэмцээний тоглолт болгон амар байгаагүй, нэлээд хүнд учраануудтай таарсан. Тэр болгонд бид өөрт байгаа бүхий л нөөц боломжуудаа дайчлан, аль болох самбаачилж тоглохыг эрмэлзсэн. Европын орнуудын тамирчид Азиудыг бодвол харьцангуй өндөр нуруутай тул тэдэнтэй хурд, ур чадвараараа илүүрхэж өрсөлдөх тактикийг боловсруулан тоглосон. Армийн Дэлхийн аварга шалгаруулах 3x3 сагсан бөмбөгийн анхны тэмцээний хүрэл медалийг эх орондоо авч ирсэндээ баяртай байна. Түүнчлэн Монголын тамирчид ингэж тоглоно гэж тооцоолоогүй, хүлээлтээс дээгүүр байлаа, тоглолтын ур чадварын хувьд үнэхээр чансаатай байж чадлаа гэсэн зохион байгуулагчдын үнэлгээ биднийг маш их урамшууллаа” гэв.

Ташрамд дурдахад дээрх амжилт нь CISM буюу Армийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс багийн төрлөөр медаль хүртэж буй анхны тохиолдол гэдгээрээ онцлог юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 27	🌧️ 16


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.165.00	3.175.0
EUR 🇪🇺	3.175.0	3.250.0
CNY 🇨🇳	470.00	475.00
RUB 🇷🇺	51.00	52.00
JPY 🇯🇵	22.60	23.40
KRW 🇰🇷	2.38	2.42

ЗУРХАЙ



2022.07.19 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 22

**ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ
САРЫН НЭГ ЦАГААН
МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТАХИА
ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.13-20.44

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Суудал: Уул

Энэ өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогосод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 567,857,190

Эдгэрсэн

Нийт: 539,000,442

Нас барсан

Нийт: 6,387,812

Цахим шууданд

ДЭД АХЛАГЧ Э.БУДЖАВ ОХУ-ЫН СПОРТЫН ДЭД МАСТЕРЫН БОЛЗЛЫГ ХАНГАЖЭЭ



Дэд ахлагч Энхбаатарын Батлан Үндэсний хамгаалахын их Сургуулийн Ерөнхий цэргийн ангид 2017-2018 онд суралцаж байгаад ОХУ-ыг зорьж, Кострома хотод Цацраг, хими, биологийн зэвсгээс хамгаалах цэргийн академид 3 дахь жилдээ суралцаж байна.

Тэрээр манай улсад зохион байгуулагдсан олон уралдаан, тэмцээнд амжилттай оролцсоны үр дүнд олс таталтын спортын дэд мастер, хүчний гурван төрөлт (поурлифтинг)-өөр

мөн спортын дэд мастерын болзлыг хангасан залуу тамирчин юм.

Тодруулбал, ҮБХИС-д суралцаж байхдаа 2017 онд Зэвсэгт хүчний олс таталтын аварга шалгаруулах тэмцээнээс багаараа хүрэл медаль, 2021 онд Зэвсэгт хүчний туухай өргөлтийн аварга шалгаруулах тэмцээнээс хос мөнгөн медаль мөн 2018 онд дээрх тэмцээнээс хүрэл медаль хүртэж байлаа.

Дэд ахлагч Э.Буджав нь ОХУ-д суралцах хугацаандаа туухай өргөлтөөр тууштай хичээллэсний үр дүнд олон

амжилтын эзэн болсон ажээ. Тухайлбал, тэрээр 2022 онд Азийн аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээний 68 килограммын жинд хос мөнгөн медаль, Олон улсын "Цагаан шөнө" тэмцээнээс алтан медалийг хүртээд байна. Мөн ОХУ-ын Кострома хотын аварга шалгаруулах тэмцээнээс 3 жил дараалан мөнгөн медаль, ОХУ-ын Хойд бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн амжилтыг гаргасан.

Түүний энэхүү бахдам амжилтыг үнэлж ОХУ-ын спортын дэд мастер цолыг олгосон нь бидний бахархал билээ.

ГАЛ ТҮЙМРИЙГ УНТРААЖ НӨХӨЖ БАРШГҮЙ АЮУЛААС СЭРГИЙЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Ангийн материал техникийн хангалтын албаны техник шалгах байрын дарга ахлах ахлагч Б.Саруулсайхан энэ сарын 12-ны орой 19 цагийн орчимд БЗД-ийн 22 дугаар хороонд байрлах орон сууцанд гарсан гал түймрийг унтрааж болзошгүй аюулыг таслан зогсоосон байна. Уг байр нь тус ангийн соёл мэдээллийн төвийн зэргэлдээ байрладаг юм.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА



БАРИЛГАЧИН ДАЙЧИД БЭСРЭГ НААДАМ ХИЙЛЭЭ



Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг угтан Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн барилгачин дайчид "Бэсрэг наадам"-ыг зохион байгуулав. Анх удаа болж буйгаараа онцлог уг наадмын хүрээнд Үндэсний бөхийн барилдаан, сур харваа, шагайн

наадгайнууд, сээр шалгах наадгай, "Цэц мэргэн" дартс шидэлт, 32 цагаан лонхыг хэн сайн тоолох вэ зэрэг тэмцээн уралдаануудыг явуулсан юм. Эдгээр тэмцээн уралдаануудад ангийн захирагчаасаа байлдагч хүртлээ идэвхтэй оролцож аваргуудаа өргөмжлөл

дурсгалын зүйлсээр шагнаж урамшуулав. Түүнчлэн наадмын үеэр азын сугалаа явуулж, азтанууддаа монгол ахуйн дурсгалын зүйлс гардууллаа. Ийнхүү тус ангийн бие бүрэлдэхүүн нэг өдрийг хамт олноороо сэтгэл хангалуун, баяр жаргалаар дүүрэн үдэв.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ



Б.МӨНХЗАЯАГИЙН БЭРТЭЛ СЭДЭРСЭН Ч ТЭСВЭР ЗААН БАРИАНДАА ОРОВ



Монголын хөнгөн атлетикийн шилдэг тамирчдын нэг ОУХМ, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн ахлагч Б.Мөнхзаяа АНУ-ын Орегон мужид болж буй ДАШТ-д оролцож, марафоны төрөлд 2:46:09 гэсэн амжилтаараа 30 дугаар байрт шалгарлаа. Б.Мөнхзаяагийн тухайд уралдааны эхэн хэсэгт толгой группт гүйж байсан ч хуучин бэртэл нь сэдэрч, саарсан ч тамирчин хүний тэсвэр тэвчээрийг харуулан бариандаа орж, уралдаанаа дуусгаж чадав.

Уралдааны дараа тэр бээр өөрийн цахим хуудаснаа "Орегон-2022 хөнгөн атлетикийн ДАШТ сайхан болж байна.Цаг агаар уур амьсгал сайхан. Олон төрөлд тэмцээний дээд амжилт эвдэгдэж байна. Манай улсаас дөрвөн тамирчин марафоноор эрхээ авч сайхан

уралдаж, өндөрлөлөө. Марафонд замаа дуусгаж хувийн амжилтаа ахиулж оролцох нь хамгийн том амжилт байгаа юм. Миний хувьд өмнөх бэртэл маань эргэж сэдэрсэн учир өөртөө хангалттай сэтгэл ханамжтай уралдаж чадсангүй. Тамирчин хүн хамгийн гол нь бэртэл гэмтлээс л хол байх хэрэгтэй. Тэмцээн уралдаан үүгээр дуусахгүй ээ. Дараа дараагийн уралдаандаа та нартаа илүү том амжилтаар бэлэг барих болно. Миний ард үргэлж бат байж чаддаг гэр бүл, ахан дүүс, хамаатан садан, үргэлж дэмжиж байдаг Биеийн тамир спортын улсын хороо, Үндэсний шигшээ баг, Зэвсэгт хүчний 327 дугаар анги, бүх гүйлтийн клуб болон гүйлт сонирхогчид, мөн баг хамт олон та бүхэндээ маш их баярлалаа гэж хэлье. Монголчууд үргэлж хамтдаа" гэжээ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)